

СҮХБААТАР АЙМГИЙН СҮХБААТАР СУМ ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2023 ОНЫ 6 ДУГААР САРЫН МЭДЭЭ

Төрийн удирдлагын чиглэлээр:

Засаг даргын тамгын газар нь байгууллагын дотоод хурлыг 7 хоног бүрийн пүрэв гаригт тогтмол хийж цаг үеийн асуудлаар мэдээлэл солилцож, удирдлагаас өгсөн үүрэг даалгаварын биелэлтийг хангаж ажиллаж байна. Энэ сарын 1нд хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тэмдэглэн өнгөрүүлж хүүхдүүдийн нас насны онцлогт тохируулан 5 төрлийн тэмцээн уралдаан зохион байгуулж шагнаж урамшуулсан. Мөн энэ өдөр сурлага, урлага спортоор амжилт гаргасан сурагчидад болон Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд , зорилтод өрхийн нийт...хүүхдийг зуслангийн эрхийн бичгээр шагнаж урамшуулсан.

Аймгийн Засаг даргын А/317 тоот захирамж сумын засаг даргын А/73 тоот захирамжийн дагуу жилийн мал тооллогын ажлыг 5.30-6.15-ны өдрийн хооронд зохион байгуулж 5 тооллогын групп гарч 171 өрхийн малыг түүврээр тоолж цахимд шивж баталгаажуулсан.

“НЭГДЬЕ, НИЙЛБЕ” ХАМТАРЪЯ ХАМЖЪЯ уриан дор малчдын бүлгийн ахлагч нарыг хамруулж анхдугаар хэлэлцүүлэг зохион байгуулсан. Уг хэлэлцүүлгээ иргэдэд Татвар, нийгмийн даатгалын тухай хууль, бэлчээр ажиглалтын журам зэрэг асуудлаар мэдээлэл өгч ажилласан. Хэлэлцүүлэгт 5 багийн 98 иргэн хамрагдсан.

Бага насны хүүхдийг зам тээврийн осол хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр Хууль зүйн хэлтэс, цагдаагийн газрын хамтарсан мэдээлэл сургалтанд цахимаар хамрагдаж хууль зүйн хэлтсээс бэлтгэн ирүүлсэн анхааруулга зурагт хуудсыг , сумын цагдаагийн тасагтай хамтран айл өрхт танилцуулан, гаднаа зориулалтын машины зогсоолтой болох талаар мэдээлэл өгч ажиллаж байна.

Монгол улсын засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол, аймгийн засаг даргын 2021 оны А/343 дугаар захирамжаар баталсан журмыг үндэслэн захиргааны байгууллагуудын хагас жилийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ үнэлгээ хийх удирдамжийн дагуу тайланг 8 чиглэлээр 07 дугаар сарын 05-ны дотор хүргүүлэхээр цахимаар тайлагнаж байна.

Байгаль орчин , Хөдөө аж ахуй, мал эмнэлгийн чиглэлээр

Тэр бум мод хөтөлбөрийн хүрээнд энэ сард 7 настай нарс мод-50ш, 4 настай нарс мод 30ш нийт 80 ширхэг нарс модыг Хэнтий аймгийнавчирж сумын төвийн зам дагуу тарьж тулгуур модоор бэхлэж хашаажуулах ажил хийгдэж байна. Мөн наадмын талбайн орчимд шар хуалс модыг тойруулан торьсан. Мөн хуучин хогийн цэгийг сэргээн засаж ... модыг тарьсан.

Нийгмийн хамалжийн чиглэлээр:

Өрхийн амжиргааны түвшин тогтоох судалгааны ажил хийгдсэн ба түүврээр 40 өрх хамрагдсан.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зарлагдсан малжуулах төсөлд 5 багийн 5 өрх хамрагдсан ба тус бүр 5 сая төгрөгний малыг хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуудсан.

Эрүүл мэнд, Боловсролын чиглэлээр:

- ЭМТөвд төрсөн эх – 2
 - Нийт төрсөн эх – 25
 - Нас баралт –11 / хавдар-3, бусад-8/
- Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгч – 284
 - Ор хоног – 1962
 - Нийт үзлэг – 3357
 - Эрэгтэй – 1480
 - Эмэгтэй – 1877
- Урьдчилан сэргийлэх үзлэг –1201
- Идэвхитэй хяналт – 1021
- Жирэмсний хяналт-21/18/86%
 - Амбулаторийн үзлэг – 919
 - Анхан – 409
 - Давтан – 566
 - Гэрийн дуудлага – 198
 - Халдварт өвчлөл – 2
 - Шинэ-2
 - Хуучин -0
 - Түргэн тусламжийн дуудлага – 343
 - Алсын дуудлага – 218
 - Осол гэмтлийн дуудлага – 11
 - Эрт илрүүлэг үзлэг
 - Хөхний өмөн – 870/505/63,1%
 - Умайн хүзүүний өмөн – 220/51/ 23.1%
 - Артерийн даралт ихдэлт – 940/735/78.1%
 - Чихрийн шижин – 1400/705/50.3%
- Сургалт сурталчилгаа
 - Тараах материал-9
 - Цахим хуудас-58 төрлийн мэдээлэл байршуулж 12132 хүний хандалт
 - Танхимын сургалт -11 удаа 306 хүн хамруулсан

Цэцэрлэгийн хүүхдүүдэд амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэг хийж, А витамин уулгасан. Багш сурагчидад зөвлөгөө өгч нийт 126 хүүхдүүд хамрагдсан.

Дотоод байрын 72 хүүхдүүдэд урьдчилан сэргийлэх үзлэг хийж, зөвлөгөө өгсөн.

Засгийн газрын 2011 оны 339-р тогтоолоор батлагдсан “Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах журам”, МУЗГ-ын 2011 оны 340 -р тогтоолоор батлагдсан Гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх журмыг тус тус хэрэгжүүлэн 2023 оны 6 сарын 8-ний өдрийн 16:00 цагт гамшгийн зарлан мэдээллийн дуут дохио дуугаргаж, ажлын байран дээр дадлага сургууль хийгдлээ. Гамшгийн үеийн хариу арга хэмжээг авах, анхны тусламжийн биксний бэлэн байдалыг эрүүл мэндийн төвийн 11 эмч ажилчдад танилцуулж, аваарын гарц, хаалгаар хэрхэн гарах талаар зааж, зөвлөгөө өгөв.

Газар хөдлөх үед: тайван байх, аюулгүй газар хорогдох, газар сууж өөрийгөө халхлах, бат бөх ширээн доогуур орох гэсэн дадлага хийлгэв.

ЭМТ – ийн туслах сувилагч нар “Халдвараас сэргийлэх хяналтын чиглэлээр ЭМГ-т 2023.06.12 нд сургалтанд хамрагдуулсан.

ЭМЯ, ДЭМБ, ЭМХТ, УХТЭ, ХӨСҮТ хамтарсан ажлын хэсэг АЗДТГ, ЭМГ -тай хамтран "Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, үйлчлүүлэгчийн аюулгүй байдал" сэдэвт сургалтыг АНЭ, ӨРХ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ, ХУВИЙН ХЭВШЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН 110 эмч эмнэлгийн мэргэжилтнүүдэд 2 өдрийн сургалтыг зохион байгуулсан. Энэ сургалтанд 3 эмч НЭМА 4 хүн хамрагдсан. 2023.06.13-14 нд.

18-34 насны залуучуудын эрт илрүүлэг үзлэгийг сумын Эрүүл мэндийн төвтэй хамтран Аймгийн нэгдсэн эмнэлэгийн эмч нар ирж 2023 он 06-р сарын 22, 23 өдрүүдэд зохион байгуулсан. ЭХО, Рентген, ЗЦБ, Дотрын үзлэг, Цусны дэлгэрэнгүй, В, С вирус, ДОХ, Тэмбүү шинжилгээг нийт – 40 хүн үзлэг шинжилгээнд хамрагдсан.

"АХИЦ-АМЖИЛТ-ҮР ДҮН" Сургуулийн өмнөх боловсролын 24 байгууллагын 2022-2023 оны хичээлийн жилийн үйл ажиллагааны тайланг хэлэлцэх, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх СӨББ-ын удирдах ажилтны сургалт семинар 2023 оны 06.08-09 зохион байгуулагдаж байна.

1. Цэцэрлэгийн эмч Ц.Туяатай, Б.Мөнхзаяа нар 6-н Бүлгийн 128 хүүхдийн амны хөндий, Шүдний үзлэгийг хийж өвчлөлтэй 48 хүүхдийн 53 шүдийг зуны амралтаар эрүүлжүүлж ирэх даалгаврыг эцэг эхэд үүрэг өгч ажилласан.

2. “Эрүүл хүүхэд” аяны хүрээнд Сумын цагдаагийн хэсгийн Олон нийтийн байцаагч Э.Эрдэнэбаатартай хамтран “Аюулгүй гарц” сургалтыг цэцэрлэгийн 5-н Бүлгийн 183 хүүхдэд зохион байгуулсан.
3. 2022-2023 оны хичээлийн жилийн хамран тойргийн 2-3 настай хувилбарт сургалтын багцыг Баянгол 1-р багийн 12 хүүхдэд хүргэж ажилласан. Мөн цэцэрлэгийн Зуны сургалтыг 2-3 настай цэцэрлэгт огт хамрагдаагүй 20 хүүхдэд зохион явуулж байна.
4. Цэцэрлэгийн багш ажилчид өөрийн эзэмшлийн хүлэмжинд өргөст хэмх, гадаа тайлбайд төмс, өнгөт цэцэгийн мандал зэргийг тарьсан.
5. НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр хэрэгжиж буй “Таблеттай багш” хөтөлбөрийн гэр бүлд суурилсан бага наны хүүхдийн хөгжил, боловсролыг дэмжих сургалт хөтөлбөрийн хүрээнд 13 сумын СӨБ-ын хувилбар сургалтын багш нарт “Гэр бүлд бага насны хүүхдийн хөгжил, боловсролыг дэмжих сургалтыг зохион байгуулсан Үүнд Цэцэрлэгийн туслах багш Б. Хоролсүрэн 2023 06.19- 06.21 ны хооронд сургалтанд хамрагдсан.

СОЁЛ УРЛАГ ИЙН ЧИГЛЭЛЭЭР:

- Ирсэн бичиг – 4
- Явсан бичиг – 2
 - Хариутай бичиг – 2
 - Хугацаандаа явсан бичиг – 2
 - Хугацаа болоогүй бичиг – 0
 - Хугацаа хэтэрсэн бичиг – 0

НЭГ: ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР:

Соёлын сэргэлт-2023 аяныг Соёлын яам, Монгол улсын хүүхэд залуучуудын театр, Цагдаагийн ерөнхий газрын “Сүлд” чуулга, Сүхбаатар аймгийн Соёл урлагийн газар, Зүүн бүсийн Жишиг Соёлын төв хамтран амжилттай зохион байгуулалаа. Аяны хүрээнд 9 багц ажлуудыг зохион байгуулж, давтагдсан тоогоор 630 хүн соёлын үйлчилгээ хүргэсэн. Аяны хүрээнд дараах үйл ажиллагааг зохион байгуулсан болно. Үүнд:

- Соён гэгээрүүлэх илтгэл:

“Амар Оюуны хөрөнгө оруулалт” төвийн илтгэгч Ч.Сайхнаа “Үндэсний нэгдмэл үнэт зүйл, эв нэгдэл” сэдвээр хүүхэд багачууд болон иргэд олон нийтэд зориулан илтгэл тавилаа.

- **Орон нутаг судлах музейн нээлттэй үзүүлэлг**

Сүхбаатар сумын Орон нутаг судлах музей нь 1981 онд байгуулагдсан. 507 үзмэр бүхий “Угсаатны танхим”, “Байгалийн танхим”, “Д.Сүхбаатарын танхим”, “Орон нутаг судлах танхим” гэсэн үзвэрийн 4-н танхимтай 2 давхар барилгад үйл ажиллагаагаа явуулж байна. Тус музейд 1860-аад оны үед бүтээгдсэн **“Нутгийн дэлгэрэнгүй зураг”**, 17 дугаар зууны үед холбогдох Монгол цэргийн баатрын Очирваань бурханы хөргийг дүрслэсэн, Монгол хээн чимэглэлтэй **“Төмөр дуулга”**, Алдарт хурдан хүлэг **“Нийгэм хонгор”** морины чихмэл, Д.Сүхбаатар Жанжны хөрөг бүхий “Зээгт наамал”, “Хатгамал”, “Зэс хөөмөл” гэх мэтээр Монголын түүхэнд холбогдох ховор нандин үзмэрүүд байршиж байна. 2023 онд Ардын хувьсгалын удирдагч их Жанжин Д.Сүхбаатарын мэндэлсний 130-н жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх, баатарлаг үйл хэргийг нь сурталчлан таниулах, ирээдүй хойчид эх оронч үзэл, Монгол бахархалыг төлөвшүүлэх зорилгоор Сүхбаатар сумын "Орон нутаг судлах музей", "Сүхбаатар аймгийн Угсаатны зүйн музей"-тэй хамтран **"Жанжны алдар"** үзэсгэлэнг амжилттай зохион байгуулсан. Хамтарсан үзэсгэлэнд 6 нэр төрлийн 150 гаруй дэглэгдсэн.

Сүхбаатар сумын Улсын тэргүүний цэцэрлэгийн хүүхэд багачуудын **“Дэлхий дүүрэн бага нас”** урлагийн тоглолтыг 2023.05.31-ний өдөр танхимаар зохион байгуулж, 2-5 бүлгийн 220 хүүхдийг хамруулан 102 хүнд хүргэсэн.

Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөрт зориулсан **“Нэгдүгээрт хүүхэд”** баярын нэгдсэн арга хэмжээг Сүхбаатар сумын төрийн байгууллагууд хамтран Д.Сүхбаатарын талбайд амжилттай зохион байгуулсан. Нэгдсэн арга хэмжээний хүрээнд төрийн шагнал гардуулах, одонтой ээжүүдэд хүндэтгэл үзүүлэх болон хүүхэд багачуудад зориулсан “Манежтай жаалууд”, “Азын бөмбөг”, “ЗхЗ сагсан бөмбөгийн тэмцээн”, “Үлгэрийн ерөнтөнөөр аялах орон зай”, “Open mic”, “Ээжтэйгээ ижилсье”, “Дугуйн уралдаан”, “Гүйлтийн тэмцээн”, “Бяцхан мисс, мистер”, “Хүүхдийн номын төрөлжсөн үзэсгэлэн” зэрэг тэмцээн үйл ажиллагааг бүх л өдрийн турш зохион байгуулж нийт 416 хүнд хүрсэн болно.

Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөрт зориулж соёлын төвөөс **“Чанга шивнээ”** хөгжөөнт тэмцээнийг зохион байгуулж, шагналын санд 60.000 төгрөгийг зарцуулсан. Тэмцээнд 42 хүүхэд хамрагдсан.

Цэцэрлэгийн насны хүүхдийн дунд зохион байгуулагдсан Сүхбаатар амйгийн **“Шувуухай”** урлагийн наадамд Сүхбаатар сумын Улсын тэргүүний цэцэрлэг “Гоцлол дуу”, “Хамтлаг дуу”, “Язгуур урлаг”, “Хамтлаг бүжиг”, “Гоцлол бүжиг” зэрэг 5 төрөл дээр шагналт 5-н байранд шалгарч, тэргүүн байр эзлэн гранпри хүртсэн.

Соёлын сайдтай байгуулсан 2023 онд хамтран ажиллах гэрээ болон Соёл урлагийн газрын даргатай байгуулсан 2023 онд хамтран ажиллах гэрээний биелэлтийг эхний хагас жилийн байдлаар хугацаанд нь тайлагнасан

Хагас жилийн үйл ажиллагааны хяналт шинжилгээний үнэлгээний тайланг цахим системд тайлах ажил үргэлжилж байна.

ХОЁР: НОМЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА:

. Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөрт зориулж соёлын төвийн номын сангаас **“Хүүхдийн номын төрөлжсөн үзэсгэлэн”**-г Соёлын өвийн танхимд зохион байгуулсан. Номын үзэсгэлэнг 28 хүн үзэж сонирхсон.

6-р сард шинэ уншигч-2, ирэгсэд 85 гэрээр олгосон ном 9 танхимаар олгосон ном 98 нийт 117 ном олгосон. Шинэ номын үзэсгэлэн-1 удаа 70 ширхэг номоор 68 хүүхдэд үйлчлэв.

ГУРАВ: СОЁЛЫН ӨВИЙН ЧИГЛЭЛЭЭР:

. Сүхбаатар сумын орон нутаг судлах музейг МУИС-ийн газар зүйн танхимын багш оюутнууд хээрийн дадлагын судалгааны ажлын зорилгоор үзэж сонирхов. Нийт 23 хүнд тайлбар хийж үзүүлэн музейн үйлчилгээ хүргэсэн.

Монголын урчуудын эвлэлийн гишүүн, Ардын урлаг судлаач, Сүхбаатар аймаг дахь урчуудын эвлэлийн холбооны тэргүүн зураач Ёндонгийн Бадарчийн “Урлагийн гавъяат зүтгэлэн” цол хүртсэний тайлан үзэсгэлэнд Сүхбаатар сумын орон нутаг судлах музейд хадгалагддаг өөрийнх нь бүтээл болох “Д.Сүхбаатар эх нутагтаа”, “Хайдав”, “Чулуун начны хөрөг” зэрэг үзмэрүүдийг зөөврлөн байршуулж, зураачид хүндэтгэл үзүүлсэн.

Соёлын төвийн соёлын өвийн хөтөлбөрийн хагас жилийн тайланг боловсруулан хугацаанд нь хүргүүлсэн. Соёлын өвийн хөтөлбөр нь 2023 оны эхний хагас жилийн байдлаар 507 музейн үзмэр, 73 түүх соёлын үл хөдлөх дурсгал, 52 өвлөн уламжлагч, тахилгатай 14 уул овоод, иргэдийн гар дээрх соёлын биет 96 өв, соёлын баримтат 143 өв Монгол орны түүхийн үнэт ховор өвүүдийн бүртгэл мэдээллийг хөтлөн, судлан дэлгэрүүлж, цахимаар болон цаасан суурьтайгаар архивлан хадгалж байна.

ДӨРӨВ: ДУГУЙЛАНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА:

Суурь боловсролоо эзэмшин төгсөж байгаа Ерөнхий боловсролын сургуулийн Э.Мягмарсүрэн багштай 9А анги, Ш.Батболд багштай 9Б ангийн сурагчдын **"Авьяасаар хөглөгдсөн сурагч нас"** урлагийн тоглолтыг Соёлын төвийн дуу хөгжмийн багш Л.Батжаргал, сургуулийн дуу хөгжмийн багш Л.Баттайван нар бэлтгэн олон нийтэд толилууллаа. Тус тоглолтыг танхимаар 185 хүн үзэж сонирхсон болно.

Дуу хөгжмийн багш Л.Батжаргал ЕБС-ийн сурагчдад ятга хөгжмийн дугуйланг 6 дугаар сард 3 удаа хичээллүүлэлээ. Ятга хөгжмийн дугуйланд нийт 12 хүүхэд хамрагдсан.

Ардын хувьсгалын 102 жил, Сүхбаатар сум үүсэн байгуулагдсаны 99 жилийн ойн сумын баяр наадмын бэлтгэлийн ажил үргэлжилж байна. Наадмын нээлтийн үйл ажиллагааны бүжгийн бэлтгэл хийгдэж байна.

ТАВ: БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА:

Монгол улсын Соёлын тухай хуулийн 20.1.1, Монгол улсын Засгийн газрын 2023 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 185 дугаар тогтоолоор батлагдсан журмыг үндэслэн Соёлын төвийн дуу хөгжмийн багш Л.Батжаргал, номын санч А.Цэцэгмаа, техникч Б.Батболд нарт 5-н жилийн тэтгэмж болох 13.892.790 төгрөгийг олгосон.

Сумын удирдагуудаас иргэдээ сонсох хурал уулзалтыг соёлын төвийн танхимд зохион байгуулан 52 хүнийг хамруулсан.

Ерөнхий боловсролын сургуулийн төгсөгчдийн гэрчилгээ гардуулах үйл ажиллагааг Соёлын төвийн танхимд зохион байгуулан 105 хүнийг хамруулсан.

Монгол улсын хэмжээнд газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх Стратегийн Команд штабын сургуулийг 2023.06.08-ны өдөр явуулав. Үүнд дараах ажлуудыг зохион байгуулсан. Үүнд:

- Сургалт хийсэн тухай

Байгууллагын гурван албан хаагчдад 2023 оны 06-р сарын 08-ний 15:30 минутанд “Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх” алхамуудын талаарх сургалт зохион байгуулав. Мөн аранз буюу гамшгийн үеийн бэлэн байдлын цүнхийг нэг бүрчлэн шалгав.

- Байгууллагын гаднах **аюулгүй орон зайг тодорхойлсон.**

Байшин, барилга, мод, гэрэл болон цахилгааны шонгоос хол буюу байгууллагын баруун талд нээлттэй, задгай талбайг сонгосон.

- Цахилгааныг бүрэн салгасан.

Соёлын төвийн цахилгааныг эх үүсвэрээр нь салгасан.

- Дохиогоор ажиллаж, түр цугларах байранд цугларсан тухай

Гамшгийн аюулын тухай зарлан мэдээлэх дохио авч Соёлын төвийн байранд ажиллаж байсан гурван албан хаагч газар хөдлөлтийн чичирхийлэлтийн үед өөрсдийгөө хамгаалах арга хэмжээ авч, ширээн дор түр хоргодох болон, даацын хананы дагуу барилгаас гарч аюулгүй бүсийн түр цугларах байранд цугларах үйл ажиллагаа явуулав

МЭДЭЭ ГАРГАСАН :

Дотоод ажилтан, Хууль, эрх зүйн мэргэжилтэн

/С.Ариунзаяа/

ХЯНАСАН:

Засаг даргын Тамгын газрын дарга

/Ц.Сүхболд/